



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЛУУС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/01

Цагаан-Овоо

2023 оны цэргийн бүртгэл явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4, 34 дүгээр зүйл, Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/331 дүгээр тушаалаар батлагдсан "Цэргийн бүртгэл явуулах журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны Цэргийн бүртгэл явуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга:	Б.Ганчимэг (Засаг даргын Тамгын газрын дарга)
Гишүүд:	Х.Адъяасүрэн (Суварга багийн Засаг дарга)
	Б.Шинэтулга (Наран багийн Засаг дарга)
	П.Тогосмаа (Буянт багийн Засаг дарга)
	Ч.Бүрэнжаргал (Өргөдөл, гомдол, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн)

2. Сумын хугацаат цэргийн алба хаах насны болон цэргийн бэлтгэл үүрэгтэй иргэдийн бүртгэлийг 2022 оны 01 дүгээр сарын 04–с 01 дүгээр сарын 20 – ны дотор зохион байгуулахыг комиссын дарга (Б.Ганчимэг), багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Цэргийн тоо бүртгэлийн мэдээ, тайланг заасан хугацаанд Цэргийн штабт хүргүүлэн ажиллаж, шаардагдах шатахууны зардлыг Засаг даргын Тамгын газрын тээвэр шатахууны зардлаас гаргахыг (Б.Ганчимэг)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ӨЛЗИЙХИШИГ

4823010000